

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/28/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317

Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799

Цахим хаяг: Bat-Amgаланm@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Батсайхан
Утас: 70453799

Цахим хаяг: batsaikhanS@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙН ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
П.АЮУШЖАВ ТАНАА

2023.02.24 № УВА-2023/28/НА-СНА-ТЦЗ
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

989000117

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	15,340,770.00	13,958,866.28
33	АВЛАГА	15,340,770.00	8,646,866.28
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	66,866.28
335	Бусад авлага	15,340,770.00	8,580,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	8,580,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	15,340,770.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	00.00	5,312,000.00
354	Хангамжийн материал	00.00	5,312,000.00
35420	Аж ахуйн материал	00.00	435,800.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	4,876,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	39,360,300.92	51,120,082.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	39,360,300.92	51,120,082.86
392	Биет хөрөнгө	39,360,300.92	51,120,082.86
39203	Авто-тээврийн хэрэгсэл	139,000,000.00	139,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	139,000,000.00	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	105,336,628.79	130,538,628.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	-73,023,364.61	-83,439,299.31
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,629,840.00	30,749,840.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,907,203.26	-27,053,486.62
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,153,000.00	1,153,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,153,000.00	-1,153,000.00
39217	Ном	324,400.00	324,400.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	54,701,070.92	65,078,949.14
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,247,500.00	3,247,500.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,247,500.00	3,247,500.00
413	Өглөг	3,247,500.00	3,247,500.00
4136	Бусад өглөг	3,247,500.00	3,247,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг	3,247,500.00	3,247,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	51,453,570.92	61,831,449.14
51	Засгийн газрын хувь оролцоо	51,453,570.92	61,831,449.14
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	174,528,903.80	174,528,903.80
51101	Өмч: - төрийн	174,528,903.80	174,528,903.80
512	Хуримтлагдсан үр дүн	-	-
51210	Өмнөх үеийн үр дүн	123,075,332.88	112,697,454.66
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	10,377,878.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	54,701,070.92	65,078,949.14

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	883,641,900.00	1,148,678,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,000,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,000,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,000,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,000,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	881,641,900.00	1,148,678,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	84,460,000.00	208,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	70,910,000.00	178,950,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,550,000.00	29,250,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	797,181,900.00	940,478,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	797,181,900.00	940,478,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	867,906,314.15	1,138,300,421.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	867,906,314.15	1,138,300,421.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	673,895,462.41	949,972,843.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180,389,680.00	411,707,053.87
210101	Үндсэн цалин	180,389,680.00	139,292,769.17
210102	Нэмэгдэл	00.00	35,234,090.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	18,008,000.00
210104	Урамшуулал	00.00	219,172,194.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,821,439.86	50,079,831.63
210201	Тэтгэврийн даатгал	16,177,185.40	34,987,573.10
210202	Тэтгэмжийн даатгал	1,831,133.27	4,116,184.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,441,937.26	3,292,947.71
210204	Ажилгүйдлийн даатгал	306,471.53	387,039.53
210205	Эрүүл мэндийн даатгал	3,064,712.40	7,296,086.72
2104	Хангамж, бараа материалын зардал	116,780,136.40	96,935,624.00
210401	Бичиг хэрэг	12,486,997.00	6,109,090.00
210402	Тээвэр, шатахуун	81,678,720.00	77,385,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,102,382.40	4,851,164.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,512,037.00	8,589,720.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	87,955,800.00	3,940,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	65,950,000.00	00.00
210604	Урсгал засвар	22,005,800.00	3,940,500.00
2107	Томилолт, зочны зардал	25,580,500.00	26,787,000.00
210702	Дотоод албан томилолт	25,580,500.00	26,787,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,691,122.00	9,434,506.20

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,526,822.00	6,291,406.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	224,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	599,100.00	1,299,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111,600.00	100,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	999,600.00	1,498,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	229,676,784.15	351,088,328.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	127,651,200.00	247,872,560.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	94,531,670.00	89,653,550.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,493,914.15	13,562,218.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	194,010,851.74	188,327,578.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	180,658,750.00	178,706,320.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,804,100.00	23,452,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	156,854,650.00	155,253,520.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,352,101.74	9,621,258.02
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,352,101.74	9,621,258.02
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>15,735,585.85</u>	<u>10,377,878.22</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	190,666.55	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	190,666.55	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-190,666.55	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>15,544,919.30</u>	<u>10,377,878.22</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	881,641,900.00	1,148,678,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	881,641,900.00	1,148,678,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	84,460,000.00	208,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	70,910,000.00	178,950,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,550,000.00	29,250,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	797,181,900.00	940,478,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	797,181,900.00	940,478,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	881,641,900.00	1,148,678,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	881,641,900.00	1,148,678,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	687,631,048.26	963,811,491.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180,389,680.00	411,707,054.87
210101	Үндсэн цалин	180,389,680.00	139,292,770.17
210102	Нэмэгдэл	00.00	35,234,090.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	18,008,000.00
210104	Урамшуулал	00.00	219,172,194.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,821,439.86	50,146,696.91
210201	Тэтгэврийн даатгал	16,177,185.40	34,987,573.10
210202	Тэтгэмжийн даатгал	1,831,133.27	4,116,184.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,441,937.26	3,292,947.71
210204	Ажилгүйдлийн даатгал	306,471.53	387,039.53
210205	Эрүүл мэндийн даатгал	3,064,712.40	7,362,952.00
2104	Хангамж, бараа материалын зардал	116,560,236.40	97,539,824.00
210401	Бичиг хэрэг	12,486,997.00	6,109,090.00
210402	Тээвэр, шатахуун	81,678,720.00	77,385,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,102,382.40	4,851,164.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,292,137.00	9,193,920.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	107,005,200.00	29,578,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	84,999,400.00	25,637,800.00
210604	Урсгал засвар	22,005,800.00	3,940,500.00
2107	Томилолт, зочны зардал	25,580,500.00	26,787,000.00
210702	Дотоод албан томилолт	25,580,500.00	26,787,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,691,122.00	9,434,506.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,526,822.00	6,291,406.20

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	224,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	599,100.00	1,299,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111,600.00	100,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	999,600.00	1,498,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	224,582,870.00	338,618,110.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	130,051,200.00	250,740,560.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	94,531,670.00	87,877,550.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	194,010,851.74	184,866,808.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	180,658,750.00	166,665,550.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,804,100.00	23,452,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	156,854,650.00	143,212,750.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,352,101.74	18,201,258.02
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,352,101.74	18,201,258.02
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	174,528,903.80	00.00	-151,377,660.21	23,151,243.59
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	174,528,903.80	00.00	-151,377,660.21	23,151,243.59
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	15,544,919.30	15,544,919.30
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	174,528,903.80	00.00	-123,075,332.88	51,453,570.92
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	174,528,903.80	00.00	-123,075,332.88	51,453,570.92
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	174,528,903.80	00.00	-123,075,332.88	51,453,570.92
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	10,377,878.22	10,377,878.22
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	174,528,903.80	00.00	-112,697,454.66	61,831,449.14

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	940,478,300.00	930,857,041.98	9,621,258.02	98.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	940,478,300.00	930,857,041.98	9,621,258.02	98.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	773,358,800.00	764,191,491.98	9,167,308.02	98.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	413,823,200.00	411,707,054.87	2,116,145.13	99.49
210101	Үндсэн цалин	143,178,600.00	139,292,770.17	3,885,829.83	97.29
210102	Нэмэгдэл	32,416,900.00	35,234,090.45	-2,817,190.45	108.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,400,000.00	18,008,000.00	-9,608,000.00	214.38
210104	Урамшуулал	229,827,700.00	219,172,194.25	10,655,505.75	95.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,777,100.00	50,146,696.91	2,630,403.09	95.02
210201	Тэтгэврийн даатгал	36,643,800.00	34,987,573.10	1,656,226.90	95.48
210202	Тэтгэмжийн даатгал	4,033,300.00	4,116,184.57	-82,884.57	102.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,226,700.00	3,292,947.71	-66,247.71	102.05
210204	Ажилгүйдлийн даатгал	806,600.00	387,039.53	419,560.47	47.98
210205	Эрүүл мэндийн даатгал	8,066,700.00	7,362,952.00	703,748.00	91.28
2104	Хангамж, бараа материалын зардал	97,877,500.00	97,539,824.00	337,676.00	99.66
210401	Бичиг хэрэг	6,900,000.00	6,109,090.00	790,910.00	88.54
210402	Тээвэр, шатахуун	77,462,500.00	77,385,650.00	76,850.00	99.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,315,000.00	4,851,164.00	-536,164.00	112.43
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,200,000.00	9,193,920.00	6,080.00	99.93
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,713,300.00	29,578,300.00	135,000.00	99.55
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,700,000.00	25,637,800.00	62,200.00	99.76
210604	Урсгал засвар	4,013,300.00	3,940,500.00	72,800.00	98.19
2107	Томилолт, зочны зардал	29,006,200.00	26,787,000.00	2,219,200.00	92.35
210702	Дотоод албан томилолт	29,006,200.00	26,787,000.00	2,219,200.00	92.35
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,226,000.00	9,434,506.20	791,493.80	92.26
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,970,000.00	6,291,406.20	678,593.80	90.26
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	224,000.00	224,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,400,000.00	1,299,100.00	100,900.00	92.79
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	100,000.00	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	1,498,000.00	2,000.00	99.87
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,000.00	00.00	10,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	139935500.00	138998110.00	937,390.00	99.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,972,400.00	60,420,560.00	551,840.00	99.09

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	78,963,100.00	78,577,550.00	385,550.00	99.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	167119500.00	166665550.00	453,950.00	99.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	167,119,500.00	166,665,550.00	453,950.00	99.73
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,452,800.00	23,452,800.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	143,666,700.00	143,212,750.00	453,950.00	99.68
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	940,478,300.00	940,478,300.00	0.00	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	940,478,300.00	940,478,300.00	0.00	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	940,478,300.00	940,478,300.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /				
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		208,200,000.00	-208200000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		208,200,000.00	-208200000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		199,620,000.00	-199620000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		199620000.00	-199620000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		190,320,000.00	-190320000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		9,300,000.00	-9300000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		8,580,000.00	-8580000.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		8,580,000.00	-8580000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		208200000.00	-208200000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		208,200,000.00	-208200000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		178,950,000.00	-178950000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		29,250,000.00	-29250000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нутгийн өөрөө удирдах байгууллагын хууль ёсоо дээдлэн, ил тод байдлыг хангасан, аймгийн хөгжлийн бодлогыг иргэдийн эрх ашигт нийцүүлэн оновчтой

тодорхойлон хэрэгжилтийг хангуулж, иргэдийн эрх чөлөөтэй, ая тухтай ажиллаж амьдрах нөхцөл боломжоор хангах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01-р сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ний өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,377.8 мянган төгрөгөөр буюу 41.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	15,340.8	8,646.9	-6,693.9
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	0.0	5,312.0	-5,312.0
Үндсэн хөрөнгө	39,360.3	51,120.1	11,759.8
Нийт хөрөнгө	54,701.1	65,078.9	10,377.8
Өр төлбөр	3,247.5	3,247.5	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	174,528.9	174,528.9	0.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	54,701.1	65,078.9	10,377.8

Авлага дансны үлдэгдэл буурсан нь өмнөх оны 15,340.8 мянган төгрөгийг авлага буурч, тайлант онд нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлсэн үлдэгдэл 8,580.0 мянган төгрөгийг авлагаар тусгасантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл өссөн нь 436.8 мянган төгрөгийн аж ахуйн материал, 4,878.2 мянган төгрөгийн бусад хангамжийн материал үлдэгдэлтэй байгаатай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд 25,202.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 940,478.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн бөгөөд тайлант онд 940,478.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 940,478.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 940,478.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 930,857.0 мянган төгрөг буюу 83.4 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			Биелэлт
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
1	Орон нутгийн удирдлага	940,478,300.00	930,857,041.98	9,621,258.02	98.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн төсвөөс 178,950.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 29,250.0 мянга, нийт 208,200.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний бусад зардалд 190,320.0 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 9,300.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Аюушжавд танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг Засаг даргын тамгын газрын хувьд суурь үзүүлэлтийг 2022 оны санхүүгийн тайлан гарах цаглаварт хугацаа болоогүй байгаа тул 2021 оны нийт зардлын дүнгээр сонгох нь зохимжтой гэж үзлээ.

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлж, төлөвлөлтийн материаллаг байдлын түвшинг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,146,880.4 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 5,734.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4,587.5 мянган төгрөгөөр дахин хянаж шинэчлэн тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага батлагдсан төсвийг арвилан хэмнэж, хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 151 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 97,156.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	97,156.5	1	97,156.5	100%
Нийт дүн	1	97,156.5	1	97,156.5	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Авто тээврийн хэрэгслийн спидометрийн заалт, явсан км, шатахуун зарцуулалтын батлагдсан нормд тулгуурлан замын хуудасны тооцоог бодож, тээвэр шатахууны зарцуулалтад нягтлан бодох бүртгэлээрх хяналт болон зарцуулалтыг хянах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР  /С.БАТСАЙХАН/

2023 оны 02 сарын 10-ны өдөр